



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангилал тогтоох, цол, зэрэг олгох журам"-ыг нэгдүгээр, "спортын төрөл, цол зэргийн болзол"-ыг хоёрдугаар, "спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангилал тогтоох зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг гуравдугаар, "спортын цолны үнэмлэх, тэмдэгний загвар"-ыг дөрөвдүгээр, "спортын цолны нэгдсэн ангилалын болзол биелүүлсэн тамирчин, шүүгчдийг тодорхойлох анкет"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Х.Бакытжан/-т даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2014 оны А/176 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН  
ЯАМ

ХУУЛЬ АР ҮНЭН

D:\barimt\tushaal

Хуульч бусад өрсөлдөгчдийн гарын үсэг

080137

2015 оны 03 сарын 17 өдөр



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 02 өдрийн  
40 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

СПОРТЫН ТӨРӨЛ, ЦОЛ, ЗЭРГИЙН НЭГДСЭН АНГИЛАЛ ТОГТООХ,  
ЦОЛ, ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

**Нэг. Ерөнхий үндэслэл**

1.1. Монгол Улсад хөгжиж буй спортын төрөл, тэдгээрийн цол, зэргийн нэгдсэн ангилал тогтоох, болзол хангасан тамирчин, шүүгчид цол, зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

**Хоёр. Спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангилал тогтоох**

2.1 Монгол Улсад нийтлэг хөгжсөн, улсын аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр тогтмол зохион байгуулдаг спортын төрлүүдийн тамирчид, шүүгчдэд спортын цол, зэргийг олгоно.

2.2 Тамирчинд олгох спортын цол, зэрэг нь дараах ангилалтай байна.

- 2.2.1 Цол:
  - 2.2.1.1 Спортын дэд мастер
  - 2.2.1.2 Спортын мастер
  - 2.2.1.3 Олон улсын хэмжээний мастер
- 2.2.2 Зэрэг:
  - 3.1.2.1. 3 дугаар зэрэг
  - 3.1.2.2. 2 дугаар зэрэг
  - 3.1.2.3. 1 дүгээр зэрэг

2.3 Спортын шүүгчдэд олгох цол, зэрэг нь дараах ангилалтай байна.

- 2.3.1 Цол
  - 2.3.1.1 Улсын шүүгч
- 2.3.2 Зэрэг
  - 2.3.2.1 Шүүгч

2.4 Монгол Улсад хөгжиж буй спортын төрлүүд, спортын цол, зэргийн нэгдсэн нэг ангилалтай байна.

2.5 Цол олгох ангиллыг тогтоохдоо дараах шалгуурыг харгалзана. Үүнд:

- 2.5.1 Олон улсын хэмжээний мастер цолыг Олимп, тивийн наадам, Дэлхий, Тив, Дэлхийн зэрэгцэлийн болон Олон улсын "А" зэрэглэлийн тэмцээнд үзүүлсэн амжилт, нормативийг;
- 2.5.2 Спортын мастер цолыг олон улсын тэмцээн, үндэсний хэмжээний спортын наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээн, лигийн тэмцээнд үзүүлсэн амжилт, норматив, олон улсын спортын холбооноос гаргасан чансаа, зэрэглэлийг;
- 2.5.3 Спортын дэд мастер цолыг үндэсний хэмжээний спортын наадам,

улс, аймаг, хотын аварга шалгаруулах тэмцээн, лигийн тэмцээнд үзүүлсэн амжилт, норматив, үндэсний хэмжээний чансаа, зэрэглэлийг үндэслэн;

2.5.4 Улсын шүүгч цолыг улс, олон улсын чанартай тэмцээнийг шүүсэн туршлага, шүүгчийн мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, холбооны шүүгчийн зөвлөлийн шалгалтын дүн, шийдвэрийг;

2.5.5 Зэрэг олгох ангиллыг тухайн спортын холбооны цол, зэргийн зөвлөл тогтооно.

2.6 Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй спортын холбоо нь "Спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангиллыг шинэчлэх, нэмэлт оруулах тухай саналыг Зөвлөлд тухайн оны 11 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлж, зөвлөл хэлэлцэж дүгнэлт гарган Сайдын тушаалаар баталгаажуулж дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### **Гурав. Спортын цол, зэрэг олгох**

3.1 Спортын холбоо нь спортын цол, зэргийн зөвлөлтэй байх бөгөөд уг зөвлөл тамирчинд энэ журмын 2.2.2, 2.3.2-т заасан зэргийг тухайн спортын төрлөөр зэрэг авах болзол хангасан тамирчин, шүүгчдийн хүсэлтийг хянан хэлэлцэж олгоно.

3.2 Нэг спортын төрлөөр хоёр ба түүнээс дээш спортын холбоо үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд спортын цол, зэргийн нэг зөвлөлтэй байх ба холбоо тус бүрийн төлөөллийн оролцоог тэгш хангасан байна.

3.3 Энэхүү журмын 2.2.1, 2.3.1-т заасан цолны болзол хангасан тамирчин, шүүгчийн хүсэлтийг тухайн спортын холбоо нь хүлээн авч холбооныхоо цол, зэргийн зөвлөлийн дүгнэлтийн үндсэн дээр [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) цахим хуудсаар анкетыг бүртгүүлж баталгаажуулсны дараа дор дурдсан материалын хамт биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад сар бүрийн 20-ны дотор хүргүүлнэ.

3.3.1 тухайн спортын холбооны албан хүсэлт;

3.3.2 тухайн спортын холбоогоор баталгаажуулсан анкет;

3.3.3 зөвлөлийн хурлын тэмдэглэл;

3.3.4 тухайн болзлыг хангасан тэмцээний албан ёсны тэмдэглэлийн баталгаат хуулбар;

3.3.5 өргөмжлөл, дипломын баталгаат хуулбар;

3.4 Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цол, зэргийн асуудал хариуцсан мэргэжилтэн нэр дэвшигчийн материалыг хүлээн авч 10 хоногийн дотор хянан үзэж, болзол хангасан тамирчин, шүүгчдэд Сайдын тушаалаар спортын цол олгоно.

3.5 Спортын цолны үнэмлэх, тэмдгийг үнэ төлбөргүй олгоно.

3.6 Цолонд нэр дэвшигчийн баримт бичгийг буцаан олгохгүй, архивын нэгж болгон хадгална.

3.7 Баримт бичгийн бүрдэл гүйцээгүй материалыг тухайн спортын холбоонд дараа сарын 10-ны дотор буцаана.



3.8 Спортын цолны тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгоходоо нөхөн олгохыг хүссэн оргодол, нөхөн олгохыг дэмжсэн тухайн спортын холбооны шийдвэр, үрэгдүүлсэн тухай зарлуулсан баримтыг үндэслэн олгоно.

#### **Дөрөв. Спортын төрөл, цол, зэргийн нэгдсэн ангилал тогтоох зөвлөл**

4.1 Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд спортын төрөл, цол, зэргийн ангилал тогтоох асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргаж сайдад танилцуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.

4.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаан нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит хуралдаан жил бүрийн 12 дугаар сарын эхний хагаст, ээлжит бус хуралдаан зөвлөлийн даргын зарласнаар тухайн цаг хугацаанд хуралдаж хэлэлцсэн асуудлын талаар санал хурааж олонхийн саналыг үндэслэн дүгнэлт гаргана.

4.3 Спортын цол, зэргийн зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ нь дарга, нарийн бичгийн дарга, спортын төрлүүдийн /багийн спорт, халз тулааны спорт, оюуны спорт, цэрэгжилтийн спорт, техникийн спорт, үндэсний спортын, пара, дифлимппийн спорт/ төлөөллөөс бүрдсэн 13 хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.4 Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралд 2 удаа оролцоогүй тохиолдолд зөвлөлийн бүрэлдэхүүнээс хасах саналыг зөвлөлөөс сайдад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

#### **Тав. Бүртгэл, судалгаа**

5.1 Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тамирчин, шүүгчид олгосон спортын цолны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх асуудлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын спортын цол, зэрэг хариуцсан мэргэжилтэн хариуцна.

5.2 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь шинээр цол, олгогдсон тамирчин, шүүгчийн нэрсийг www.gov.mn цахим хуудсаар дамжуулан сар бүр олон нийтэд мэдээлнэ.



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 02 өдрийн  
...40 дугаар тушаалын 3 дугаар  
хавсралт

СПОРТЫН ТӨРӨЛ, ЦОЛ, ЗЭРГИЙН НЭГДСЭН АНГИЛАЛ ТОГТООХ ЗӨВЛӨЛ

Дарга: Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Спортын төрөл, цолны нэгдсэн ангилал тогтоох зөвлөлийн дарга

Орлогч дарга: Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын үндэсний шигшээ баг, засгийн газрын мөнгөн шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын бие бялдрын боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгааны бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Спортын бэлтгэлийн төвийн Биеийн тамир, спортын албаны дарга

Спортын бэлтгэлийн төвийн Биеийн тамир, спортын албаны мэргэжилтэн

Монголын Үндэсний Олимпын Хорооны төлөөлөл

Монголын Паралимпийн хорооны төлөөлөл

Хүчний байгууллагуудын спорт хорооны төлөөлөл

Техник спортын хорооны төлөөлөл


Спорт тоглоомын холбоодын төлөөлөл

Ганцаарчилсан спортын холбоодын төлөөлөл

Оюуны спортын холбоодын төлөөлөл

Монголын спортын сэтгүүлчдийн холбооны төлөөлөл

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 02 өдрийн  
...40 дугаар тушаалын 4 дүгээр  
хавсралт



**СПОРТЫН ЦОЛНЫ ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР**


		ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ	“.....” -н
			ТӨРӨЛД МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН МАСТЕР ЦОЛ ОЛГОВ
	№ 2015/00001		МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД
..... овогтой ..... -д			..... Г. ШИЙЛЭГДАМБА
Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны .... дүгээр сарын .... -ны өдрийн .... тоот тушаалаар			2015 оны.....сарын .....өдөр

**СПОРТЫН ЦОЛНЫ ТЭМДЭГНИЙ ЗАГВАР**





Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 02 өдрийн  
...40 дугаар тушаалын 5 дугаар  
хавсралт



МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН ЦОЛНЫ НЭГДСЭН АНГИЛЛЫН БОЛЗОЛ  
БИЕЛҮҮЛСЭН ТАМИРЧИН, ШҮҮГЧДИЙГ ТОДОРХОЙЛОХ АНКЕТ

**Спортын холбоо /**

1	Овог нэр/ бүтэн бичнэ/	
2	Хүйс	
3	Альхот, аймаг, сумандтөрсөн	
4	Болзол хангасан спортын төрөл	
5	Спортын ямар цолд тодорхойлж байна	
6	Урьд нь авсан спортын цол	
7	Урьд авсан спортын цолны тогтоолын огноо	
8	Регистрийн дугаар	
9	Харьяа аймаг, нийслэл, дүүргийн БТСГ, клуб	
10	Одоо хаана ямар ажил эрхэлдэг	

**Спортын цол, зэрэг биелүүлсэн байдал:**

Он	Тэмцээний төрөл	Амжилт	Байр

Анкет үнэн зөв бөглөсөн:

Гарын үсэг...../гарын үсгийн тайлал/

**Спортын холбооны шийдвэр:**

Спортын цол зэргийн нэгдсэн ангиллын....р үзүүлэлтийг үндэслэн спортын.....  
Цол олгуулахаар дэмжив.

Тамга,

Гарын үсэг Е.Н.Б. дарга ...../гарын үсгийн тайлал/

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 02 өдрийн  
...40 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

## СПОРТЫН ТӨРӨЛ, ЦОЛ, ЗЭРГИЙН АНГИЛАЛ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ СПОРТЫН НЭГДСЭН ТӨРЛҮҮД

#### Нэг. МОРИН СПОРТ /СОНГОМОЛ МОРИН СПОРТ/

##### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Азийн аварга шалгаруулах тэмцээн, Азийн цом, Азийн тоглолтод эхний 10 байрт, 3-аас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд эхний 3 байрт 2 удаа шалгарвал.

##### 2. Спортын мастер, дэд мастер

Морин спортын саад харайлтын тэмцээнд тамирчин бүр нэг мориор оролцоно. Саад харайлтын тэмцээнд 60х60м талбайд тавигдсан 18 саадыг харайлгана.

Бүх дасгалыг хамгийн бага цагт торгуулийн оноогүйгээр харайлгана. Цаг, торгуулийн онооны цөөнөөр байр эзлүүлж дүнг гаргана.

-Саад унагахад	4 оноо
-Морины аль нэг хөл шуудуунд орвол	4 оноо
-Тамирчин морьтой буюу мориноосоо унавал	хасагдана
-Унаж яваа морио харайлгаж чадахгүй тулвал	эхний удаад 4 оноо 2 дахь удаад 4 оноо 3 дахь удаад хасагдана.

Саад	Спортын мастер	Спортын дэд мастер
Саадны тоо	14	14
Харайлтын тоо	18	18
Бүх явалтаараа торгуулийн оноо	цэвэр	4
Саадны өндөр	130 см	2
	120 см	1
	110 см	3
	100 см	1
	90 см	2
	80 см	1
	70 см	1
3-9 м-ийн зайд тавигдсан саадны өндөр	90 см	2
	80 см	2
	60 см	1
Саадны өргөн см-ээр	Дээд тал	80-120 см
	Доод тал	100-130 см
Шуудуун саад	300 см	1



## ТЭСВЭРТЭЙ ХОЛЧ МОРИНЫ УРАЛДААН



### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Олон улсын морин спортын холбоо /FEI/-ноос хүлээн зөвшөөрсөн:

- Нэг одтой (CEI\* 40-79 km, 1 day, 70 kg, 20 mnt-56)
- Хоёр одтой (CEI\*\* 80-119 km, 1 day, 40-79 kg, 2 day, 20 mnt-64)
- Гурван одтой (CEI\*\*\* 120 km, 1 day, 80 kg, 2 day, 30 mnt-64)
- Дөрвөн одтой:

Насанд хүрэгчдийн аваргын (CEI\*\*\*\* 160 km, 1 day, 30mnt-64)

Идэрчүүдийн аваргын (CEI\*\*\*\* 120 km, 1 day, 30 mnt-64)

тэмцээнүүдэд 2 удаа тэргүүн байр эзэлбэл

1.2 Дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээн буюу тэдгээртэй адилтгах уралдаан (WEG-E, AEG-E)-д удаа дараа оролцож, замаа гүйцээн 75 хувийн амжилт үзүүлбэл.

### 2. Спортын мастер

2.1 Олон улс болон улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлэн үндэсний холбооны хүлээн зөвшөөрсөн бусад тэмцээнд эхний гурван байрт 3 удаа орвол.

### 3. Спортын дэд мастер

3.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, үндэсний холбооны хүлээн зөвшөөрсөн бусад тэмцээнд эхний гурван байрт 2 удаа орвол.

3.2 Улсын аварга шалгаруулах тэмцээн болон үндэсний холбооны хүлээн зөвшөөрсөн бусад тэмцээнд 2, 3 дугаар байрт 3-аас доошгүй удаа орвол.

### 4. Шүүгчийн цол

4.1 Улсын шүүгч цолыг Олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнд 2-оос доошгүй удаа ерөнхий шүүгчээр ажиллавал

-2-оос доошгүй удаа нарийн бичгийн даргаар ажиллавал

-3-аас доошгүй удаа цагчин шүүгчээр ажиллавал

4.2 Шүүгчийн сургалтад хамрагдаж, шүүгчээр ажиллахдаа ямар нэгэн алдаа дутагдал гаргаагүй байна.

## УЛСЫН МОРЬ БАРИАЧ

Улсын морь бариач нь улсын шүүгчтэй дүйцнэ.

1.1 Улс, бүсийн чанартай уралдааны айргийн 5 морийг 5 жил будлиангүйгээр баривал.

1.2 Бүсийн чанартай уралдаанд 10 удаа, аймгийн уралдаанд 8 жил айргийн таван морийг будлиангүйгээр баривал.

## УЛСЫН МОРЬ ЦОЛЛОГЧ

Улсын морь цоллогч нь улсын шүүгчтэй дүйцнэ.

1.1 Улс, бүсийн чанартай уралдааны айргийн 5 морийг 5 жил цоллосон.

1.2 Бүсийн чанартай уралдаанд 10 удаа, аймгийн уралдаанд 8 жил айргийн таван морийг цоллосон.

#### УУРГАЧ БУГУЙЛЧ

Уургалах, бугуйлдах төрөл тус бүрт доорх ангиллаар цол олгоно.



#### 1. Спортын мастер

1.1 Үндэсний спортын их наадам, Улсын аварга шалгаруулах уургач, бугуйлчийн тэмцээнд 2 удаа түрүүлсэн эсвэл 1-3-р байрт 3 удаа орвол.

#### 2. Спортын дэд мастер

2.1 Үндэсний спортын их наадам, Улсын аварга шалгаруулах уургач, бугуйлчийн тэмцээнд 1 удаа түрүүлсэн эсвэл 2-3 дугаар байрт 2 удаа орвол.

#### ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХЭД

#### 1. Спортын мастер

1.1 Монголын морин спорт уяачдын холбооны оны шилдэг унаач хүүхдээр 3 удаа шалгарвал.

#### 2. Спортын дэд мастер

2.1 Монголын морин спорт уяачдын холбооны оны шилдэг хүүхдээр 2 удаа шалгарвал.

Жич:

1. Оны шилдэг хурдан морь унаач хүүхэд: Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор Монголын морин спорт уяачдын холбооноос зохион байгуулж байгаа улс, бүс болон шигшмэл хурдан морины /Их хурд/ уралдаанд хамгийн өндөр амжилт үзүүлж шалгарсан хүүхдийг хэлнэ.
2. Оны шилдэг хурдан морь унаач хүүхэд шалгаруулахдаа тухайн жилд хурдан морь унаж Улсын баяр наадамд 2-оос дээш, бүсийн уралдаанд 2-оос дээш, шигшмэл хурдан морьд /Их хурд/-ын уралдаанд 1 удаа тус тус айрагдсан байна.

#### ЭМНЭГ БУЛГИУЛАЛТ

#### 1. Спортын мастер

1.1 Үндэсний спортын их наадам, улсын аварга шалгаруулах эмнэг булгиулалтын тэмцээнд 2 удаа түрүүлж, 1-3-р байрт 3 удаа орвол.

#### 2. Спортын дэд мастер

2.1 Үндэсний спортын их наадам, улсын аварга шалгаруулах эмнэг булгиулалтын тэмцээнд 1 удаа түрүүлж, 2-3 дугаар байрт 2 удаа орвол.

#### МОРИН СПОРТЫН ШҮҮГЧ

1.1 Улаанбаатар хотын аварга шалгаруулах болон түүнээс дээш шатны тэмцээнд 2-оос доошгүй удаа ерөнхий шүүгч, нарийн бичгийн дарга шүүгчээр, 3 удаа бусад шүүгчээр ажиллаж, дүрмийн шалгалтад тэнцвэл.



## Хоёр. МӨСНИЙ ШАГАЙ

### 1. Спортын мастер

- 1.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2 удаа алтан медаль авбал
- 1.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа алтан медаль хүртэж, 2 удаа медальт байрт орвол
- 1.3 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа медальт байрт орвол
- 1.4 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа медальт байр эзэлж, 72 болон түүнээс дээш оноо авбал

### 2. Спортын дэд мастер

- 2.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 удаа алтан медаль хүртэж, 2 удаа медальт байрт орвол
- 2.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 4 удаа медальт байр эзэлбэл
- 2.3 72 болон түүнээс дээш оноо авсан тамирчинд олгоно.

### 3. Улсын шүүгч

- 3.1 Мөсөн шагайн бүс болон улсын аварга шалгаруулах тэмцээнд 5-аас дээш удаа шүүгчээр ажиллаж, тэмцээний дүрмийг судлан, зохион байгуулах дадлага, арга барилыг эзэмшсэн бол олгоно.

## Гурав. СУРЫН СПОРТ /БУРИАД СУР/

### 1. Уламжлалтаар

№	Төрөл	Зай /м/	Харвах сумны тоо	Спортын мастер	Спортын дэд мастер
1	Эмэгтэй, эрэгтэй	30, 45	64	56-59	53-55

### 2. Олон улсын тэмцээний дүрмээр

Улсын наадам, олон улсын чанартай тэмцээн болон тусгай удирдамжаар өндөр зэрэглэлийн харваачдын дунд зохион байгуулсан харвааг их онооны системээр байр эзлүүлж тухайн тэмцээнд оролцсон нэг харваачийн харвасан нийт сумны 75 хувиас дээш оноо авбал спортын мастер, 67 хувиас дээш оноо авбал спортын дэд мастер цол олгоно.

## УЛАМЖЛАЛТ ХАРВАА

### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Тив, дэлхийн аварга шалгаруулах 15-аас дээш улс орсон тэмцээнээс ганцаарчилсан болон багийн төрлөөр эхний 3 байранд орвол
- 1.2 Олон улсын чанартай 8-аас дээш улс орсон ганцаарчилсан болон багийн төрлөөр эхний 3 байрт 2 удаа шалгарсан тохиолдолд

### 2. Спортын мастер

- 2.1 Улсын аварга шалгаруулах харвуул наадамд 5-н байг харвах буюу нийт 75 оноог авахаас 50, түүнээс дээш оноо авсан тохиолдолд


### 3. Спортын дэд мастер

3.1 Улсын аварга шалгаруулах харвуул наадамд 45-аас 49 оноо авсан тохиолдолд

### 4. Улсын шүүгч

4.1 Монголын уламжлалт харвааны холбооноос зохион байгуулсан шүүгчийн сургалтад хамрагдан батламж авсан байна.

4.2 Олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнд 6-8-н удаа шүүгчээр ажиллаж, ямар нэгэн алдаа дутагдалгүй гаргаагүй байна.



## УРИАНХАЙ СУР

### 1. Спортын мастер, спортын дэд мастер

Урианхай сурын холбооноос зохион байгуулж явуулсан нээлтийн харваа, Улсын аварга шалгаруулах тэмцээн, Үндэсний их баяр наадмын харваа, өвлийн улирлын нээлтийн харваа, отго харваа, бүсийн тэмцээн, урлаг спортын их наадмын цуваа харвааны төрөлд дараах болзол биелүүлвэл олгоно.

д/д	Спортын цол	Харвах сумны тоо	Болзол биелүүлэх нөхцөл
1	Спортын мастер	30	22 буюу түүнээс дээш оносон
2	Спортын дэд мастер	30	21 оносон

Урианхай сурын мөсөн дээрх харваа

д/д	Спортын цол	Харвах сумны тоо	Болзол биелүүлэх нөхцөл
1	Спортын мастер	20	16 буюу түүнээс дээш оносон
2	Спортын дэд мастер	20	15 оносон

### 2. Улсын шүүгч


2.1 Шүүгчийн сургалтад хамрагдсан, улсын чанартай тэмцээний шүүгчээр 5 удаа ажилласан эсвэл аймаг, хотын чанартай тэмцээний шүүгчээр 10-аас дээш удаа ажилласан бол

## ҮНДЭСНИЙ СУР

№	Хүйс, нас	Зай /м/	Спортын төрөл	Спортын мастер	Спортын дэд мастер
1	Эрэгтэй /насанд хүрэгчид/	75	Хана 20 Хасаа 20	32 оноо	30 оноо
2	Эмэгтэй /насанд хүрэгчид/	65	Хана 20 Хасаа 20	32 оноо	30 оноо
3	Улсын шүүгч	Үндэсний спортын цол зэрэг олгох тэмцээн, Үндэсний баяр наадмын өрөнхий шүүгч, нарийн бичгийн даргаар 6 аао доошгүй удаа, самбарын шүүгч, зурхайн шүүгчээр 10-аас доошгүй удаа маргаангүй ажилласан харваач буюу шүүгчид			



Цол зэргийг Үндэсний сурын улсын нээлтийн харваа, улсын аварга шалгаруулах цуваа харваа, Үндэсний баяр наадам, Улсын отго харваа, бүсийн чуулга харваанд олгох ба бусад харваанд олгохгүй.



## **Дөрөв. ТЭМЭЭН ПОЛО**

### **1. Спортын мастер**

- 1.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа түрүүлбэл
- 1.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлж, 2 удаа медальт байр эзэлбэл
- 1.3 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, 4 удаа медальт байрт шалгарвал

### **2. Спортын дэд мастер**

- 2.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлж, 1 удаа медальт байр эзэлбэл

### **3. Улсын шүүгч**

- 3.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа ерөнхий шүүгчээр, 1 удаа талбайн ахлах шүүгчээр ажиллавал
- 3.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд тасралтгүй 6-аас дээш удаа талбайн ахлах шүүгчээр ажиллавал
- 3.3 Улсын аварга шалгаруулах тэмцээнд туслах болон талбайн шүүгчээр 10-аас дээш жил ажиллавал.

## **Тав. Шагайн харваа**

### **1. Спортын мастер**

- 1.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 5 удаа медальт байрт шалгарвал

### **2. Спортын дэд мастер**

- 2.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа медальт байрт шалгарвал

### **3. Улсын шүүгч**

- 3.1 Шүүгчийн семинарт хамрагдаж шалгалт өгсөн, аймаг, хот, улсын тэмцээнийг 5-аас доошгүй жил ямар нэгэн алдаа мадаггүй шүүсэн байна.

## **Зургаа. МӨСӨН СУРЫН ХАРВАА**

### **Нэг. Спортын мастер**


- 1.1. Мөсөн сурын холбооноос зохион байгуулсан улсын аварга шалгаруулах тэмцээн, сар шинийн харваа, бүсийн тэмцээн, спортын их наадмын цуваа харвааны төрөлд 20 сумнаас 16 буюу түүнээс дээш оносон бол

### **Хоёр. Спортын дэд мастер**

- 2.1. Мөсөн сурын холбооноос зохион байгуулсан улсын аварга шалгаруулах тэмцээн, сар шинийн харваа, бүсийн тэмцээн, спортын их наадмын цуваа харвааны торолд 20 сумнаас 15 оносон бол

#### **Гурав. Улсын шүүгч**

- 3.1. Улсын шүүгчийн сургалтад хамрагдаж улсын чанартай тэмцээний шүүгчээр 5 удаа ажилласан эсвэл аймаг, хотын чанартай тэмцээний шүүгчээр 10-аас дээш удаа ажилласан бол



### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. БӨХИЙН ТӨРӨЛ**

#### **Долоо. БҮСТЭЙ БӨХ**

##### **1. Олон улсын хэмжээний мастер**

- 1.1 Дэлхийн цом, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал  
1.2 Тивийн спортын тоглолт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1-2 дугаар байрт шалгарвал  
1.3 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 1-2 дугаар байр эзэлбэл  
1.4 Дэлхийн универсиадын тоглолтод 1-2 дугаар байр эзэлбэл

##### **2. Спортын мастер**

- 2.1 Дэлхийн цом, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт 4-5 дугаар байр эзэлбэл  
2.2 Тивийн спортын тоглолт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байранд шалгарвал  
2.3 Дэлхийн универсиадын тоглолтод 3 дугаар байрт шалгарвал  
2.4 Өсвөр үеийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал  
2.5 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байрт шалгарвал  
2.6 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1-2 дугаар байрт шалгарвал  
2.7 10-аас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд түрүүлбэл  
2.8 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд  
а/ хоёр удаа түрүүлбэл  
б/ дөрвөн удаа медальт байрт шалгарвал  
2.9 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс алт, мөнгөн медалийг хоёр удаа авбал

##### **3. Спортын дэд мастер**


- 3.1 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа медальт байранд шалгарвал  
3.2 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр медаль эсвэл өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд гурван медаль авбал  
3.3 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байрт шалгарвал

##### **4. Улсын шүүгч**

- 4.1 Тухайн шүүгч жилдээ 6-аас доошгүй удаа тэмцээнд шүүгчээр ажилласан байна.  
4.2 Шинээр цол авах шүүгч онолын шалгалт өгч, тэнцсэн байна.



## Найм. ЖҮДО БӨХ



### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Олимпын наадамд шагналт байранд орвол /эхний 8-д багтсан тамирчид/
- 1.2 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 6 байрт шалгарвал
- 1.3 Дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 1.4 Тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 1.5 Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл
- 1.6 Мастерын, Армийн, Оюутны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 1.7 Өсвөр үеийн олимпын наадамд түрүүлбэл
- 1.8 Өсвөр үеийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл
- 1.9 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал

### 2. Спортын мастер

- 2.1 "А" зэрэглэлийн Олон улсын тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.2 Олон улсын тэмцээнд 2 удаа медальт байрт шалгарвал
- 2.3 Залуучуудын наадам, Тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байр эзэлбэл
- 2.4 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд:
  - а/ 2 удаа түрүүлбэл
  - б/ 1 удаа түрүүлж, 2 дугаар байр 2 удаа эзэлбэл
  - в/ 2 удаа 2 дугаар байр, 1 удаа 3 дугаар байрт шалгарвал
  - г/ 1 удаа 2 дугаар байр, 2 удаа 3 дугаар байр эзэлбэл
  - д/ 4 удаа медальт байрт шалгарвал
- 2.5 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байрт шалгарвал
- 2.6 Өсвөр үеийн Олимпын наадамд медальт байрт шалгарвал
- 2.7 Өсвөр үеийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.8 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлж, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал.
- 2.9 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлвэл
- 2.10 Азийн хүүхдийн наадамд түрүүлбэл

### 3. Спортын дэд мастер

- 3.1 Олон улсын тэмцээнд медальт байрт шалгарвал
- 3.2 Өсвөр үеийн Олимпын наадамд эхний 5 байрт шалгарвал
- 3.3 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд
  - а/ 1 удаа түрүүлбэл
  - б/ 2 удаа 2 дугаар байр эзэлбэл
  - в/ 3 удаа 3 дугаар байр эзэлбэл
- 3.4 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлбэл
- 3.5 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа, Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байр эзэлбэл.
- 3.6 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байр эзэлбэл

- 3.7 Насанд хүрэгчдийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа түрүүлбэл
- 3.8 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 3.9 Азийн хүүхдийн наадамд медаль хүртвэл.



### Ес. КУРАШ БӨХ

#### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Олимпын бус төрлүүдийн дэлхийн тоглолт, дэлхийн цом, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал.
- 1.2 Тивийн спортын тоглолт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1-2 дугаар байрт шалгарвал
- 1.3 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 1-2 дугаар байр эзэлбэл.

#### 2. Спортын мастер

- 2.1 Дэлхийн цом, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт 4-5 дугаар байр эзэлбэл
- 2.2 Тивийн спортын тоглолт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.3 Өсвөрийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.4 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.5 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1-2 дугаар байрт шалгарвал
- 2.6 Зургаагаас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд түрүүлбэл.
- 2.7 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд  
а/ хоёр удаа түрүүлбэл  
б/ дөрвөн удаа медальт байрт шалгарвал
- 2.8 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс алт, мөнгөн медалийг хоёр удаа авбал.

#### 3. Спортын дэд мастер

- 3.1 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа медальт байрт шалгарвал
- 3.2 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр медаль, эсвэл өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд гурван медаль авбал
- 3.3 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал

#### 4. Улсын шүүгч

- 4.1 Тухайн шүүгч жилдээ 6-аас доошгүй удаа тэмцээнд шүүгчээр ямар нэгэн алдаа дутагдалгүй ажилласан байна.
- 4.2 Шинээр цол авах шүүгч онолын шалгалт өгч, тэнцсэн байна.


### Арав. САМБО БӨХ

#### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, дэлхийн тоглолт, дэлхийн цомын тэмцээнд медальт байрт шалгарвал
- 1.2 Тивийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл



- 1.3 Тивийн тоглолтод 1-2 байрт шалгарвал
- 1.4 Цагдаа болон армийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл
- 1.5 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл



## **2. Спортын мастер**

- 2.1 Дэлхийн цом, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 6 байрт шалгарвал
- 2.2 Тивийн спортын тоглолт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байр эзэлбэл /залуучууд, насанд хүрэгчид/
- 2.3 Өсвөр, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.4 Цагдаа болон армийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медальт байрт шалгарвал
- 2.5 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1-р байр эзэлбэл
- 2.6 Зургаагаас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд түрүүлбэл
- 2.7 Монголын бүх ард түмний спортын их наадам, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд
  - а/ 2 удаа түрүүлбэл
  - б/ 4 удаа медальт байр эзэлбэл
- 2.8 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 алт, 1 мөнгөн медаль авбал.

## **3. Спортын дэд мастер**

- 3.1 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медаль авбал
- 3.2 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний 2 байр, өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа медальт байрт шалгарвал
- 3.3 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал

## **4. Улсын шүүгч**

- 4.1 Олон улсын бөхийн төрлүүдийн нэгдсэн холбооны цол олгох хэмжүүрийн дагуу 10-9 оноо авсан байна.
- 4.2 Тухайн шүүгч жилдээ 6-аас доошгүй удаа тэмцээнд шүүгчээр ямар нэгэн алдаа дутагдалгүй ажилласан байна.
- 4.3 Шинээр цол авах шүүгч онолын шалгалт өгч, тэнцсэн байна.

## **Арван нэг. СУМО БӨХ**


### **1. Олон улсын хэмжээний мастер**

- 1.1 Дэлхийн тоглолт, дэлхийн цомын аварга, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 1.2 Тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд эхний хоёр байрт шалгарвал
- 1.3 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл

### **2. Спортын мастер**

- 2.1 Дэлхийн цом, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 8 байрт шалгарвал

- 2.2 Тивийн спортын тоглолт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 6 байрт шалгарвал
- 2.3 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт байрт орвол
- 2.4 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байр эзэлбэл
- 2.5 Наймаас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд медальт байр эзэлбэл
- 2.6 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд
  - а/ 2 удаа түрүүлбэл
  - б/ 4 удаа медальт байр эзэлбэл
- 2.7 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа медальт байрт шалгарвал
- 2.8 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түрүүлэн, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа медальт байр эзэлбэл.



### **3. Спортын дэд мастер**

- 3.1 Олон улсын тэмцээнд нэг удаа эхний 2 байрт шалгарвал
- 3.2 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд
  - а/ 1 удаа түрүүлбэл
  - б/ 2 удаа 2-р байр эзэлбэл
  - в/ 3 удаа 3-р байр эзэлбэл
- 3.3 Өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлбэл
- 3.4 Өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байранд шалгарвал
- 3.5 Залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байр эзэлбэл
- 3.6 Насанд хүрэгчдийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа түрүүлбэл

## **Арван хоёр. ЧӨЛӨӨТ БӨХ, СОНГОМОЛ БАРИЛДААН**

### **ЭМЭГТЭЙ ЧӨЛӨӨТ БӨХ**

#### **1. Олон улсын хэмжээний мастер**


- 1.1 Олимпийн наадамд шагналт байрт орвол
- 1.2 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт VIII байр эзэлбэл
- 1.3 Залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байр эзэлбэл
- 1.4 Насанд хүрэгчдийн тивийн тоглолт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1-3 байр эзэлбэл
- 1.5 Универсиад наадам болон Дэлхийн Оюутны аварга шалгаруулах тэмцээнд эхний гурван байр эзэлбэл

#### **2. Спортын мастер**

- 2.1 Залуучуудын тивийн аварга шалгаруулах тэмцээнд I-II байр эзэлбэл
- 2.2 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлж, мөн тэмцээний буюу залуучуудын тивийн аваргад нэг удаа медальт байрт шалгарвал



- 2.3 Таваас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд /жиндээ 16-аас дээш бөх оролцсон/ жилдээ 2 удаа түрүүлбэл
- 2.4 Монголын Бүх ард Түмний спортын их наадам, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний
- а/ аль нэгэнд нь түрүүлбэл
  - б/ хоёр удаа медальт байрт шалгарвал
- 2.5 Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түрүүлж эсвэл нэг удаа түрүүлж, хоёр удаа хоёрдугаар байр эзэлбэл
- 2.6 Залуучуудын улсын аваргад түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.7 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байрт шалгарч, насанд хүрэгчдийн улсын аваргад медальт байранд шалгарвал
- 2.8 Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд медальт байрт орвол



### **3. Спортын дэд мастер**

- 3.1 Тивийн залуучуудын болон өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд II-III байр эзэлбэл
- 3.2 Таваас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд түрүүлбэл эсвэл хоёр удаа медальт байрт шалгарвал
- 3.3 Монголын Бүх Ард түмний спортын их наадам буюу насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд медальт байр эзэлбэл
- 3.4 Өсвөр үе, Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл
- 3.5 Залуучууд буюу өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа медальт байрт шалгарвал

## **ЭРЭГТЭЙ ЧӨЛӨӨТ БӨХ, СОНГОМОЛ БАРИЛДААН**

### **1. Олон улсын хэмжээний мастер**

- 1.1 Олимпийн наадамд шагналт байрт орвол
- 1.2 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт VIII байр эзэлбэл
- 1.3 Тивийн наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байр эзэлбэл
- 1.4 Дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд хувийн дүнгээр I-II байр буюу залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эхний гурван байр эзэлбэл
- 1.5 Дэлхийн оюутны болон Дэлхийн армийн аварга шалгаруулах тэмцээн буюу Универсиад наадамд эхний гурван байр эзэлбэл
- 1.6 10-аас дээш орон оролцсон A зэрэглэлийн олон улсын тэмцээнд түрүүлбэл

### **2. Спортын мастер**

- 2.1 Дэлхийн цом, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 8 байрт шалгарвал
- 2.2 Тивийн спортын наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 6 байрт шалгарвал
- 2.3 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт байрт орвол
- 2.4 Өсвөр үеийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.5 Наймаас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд медальт байр эзэлбэл




2.6 Монголын бүх ард түмний спортын их наадам, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд:

а/ 2 удаа түрүүлбэл

б/ 4 удаа медальт байрт эзэлбэл

2.7 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа медальт байрт шалгарвал

2.8 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлэн, залуучууд, улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа медальт байр эзэлвэл.



### **3. Спортын дэд мастер**

3.1 Олон улсын тэмцээнд нэг удаа эхний 2 байрт шалгарвал

3.2 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд:

а/ 1 удаа түрүүлбэл

б/ 2 удаа II байр эзэлбэл

в/ 3 удаа III байр эзэлбэл

3.3 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлбэл.

3.4 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа, Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байранд шалгарвал

3.5 Залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медальт байр эзэлбэл.

3.6 Насанд хүрэгчдийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа түрүүлбэл

### **4. Шүүгчийн цол**

4.1 Тухайн шүүгч жилдээ 6-аас доошгүй удаа тэмцээнд шүүгчээр ямар нэгэн алдаа дутагдалгүй ажилласан байна.

4.2 Улсын аварга шалгаруулах аль нэг тэмцээний үеэр онолын шалгалт өгч, шүүгчээр ажиллаж нэг үзүүлэлтэд өгөх оноо 9-10 ба авбал зохих оноо 90-ээс дээш байна.

## **Арван гурав. ЖЮУ-ЖИЦУ БӨХ**

### **1. Олон улсын хэмжээний мастер**

1.1. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал

1.2. Дэлхийн тоглолтод медальт байрт шалгарвал

1.3. Мастерсын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлвэл

1.4. Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлвэл

### **2. Спортын мастер**

2.1. Мастерсын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал.

2.2. Залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлвэл

2.3. Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс медальт байрт шалгарвал

2.4. Олон улсын тэмцээнд 3 удаа түрүүлвэл

2.5. Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлвэл

2.6. Улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа медаль байрт шалгарвал



### **3. Спортын дэд мастер**

- 3.1. Өсвөр үе, Залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 3.2. Олон улсын тэмцээнд 2 удаа түрүүлвэл
- 3.3. Олон улсын тэмцээнд 6 удаа медальт байрт шалгарвал
- 3.4. Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа медальт байрт шалгарвал
- 3.5. Өсвөр үе, Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлвэл



### **4. Улсын шүүгч**

- 4.1. Монголыг жюү-жицү бөхийн холбооноос зохион байгуулсан шүүгчдийн семинарт хамрагдаж шалгалтанд тэнцэж 3-аас доошгүй жил улсын чанартай тэмцээнүүдэд шүүгчээр ажилласан тохиолдолд олгоно.

## **Гуравдугаар бүлэг. СПОРТ ТОГЛООМЫН ТӨРӨЛ**

### **Арван дөрөв. БАДМИНТОН**

#### **1. Олон улсын хэмжээний мастер**

- 1.1 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хос болон ганцаарчилсан тоглолтод эхний 6 байрт шалгарвал
- 1.2 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд багаараа медальт байрт шалгарвал
- 1.3 Тивийн спортын наадам, тивийн аварга болон тивийн цомын төлөөх тэмцээнд багаараа ба ганцаарчилсан тоглолтоор эхний 4 байрт шалгарвал
- 1.4 Тивийн бүсийн спортын наадамд медальт байрт шалгарвал
- 1.5 Дэлхийн чансааны жагсаалтад эхний 200 дотор 3 сарын турш бичигдвэл

#### **2. Спортын мастер**

- 2.1 Таваас доошгүй орон оролцсон Олон улсын тэмцээнд эхний 3 байрт шалгарвал
- 2.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа, Улаанбаатар хотын АШТ-нд 4 удаа медальт байранд шалгарвал
- 2.3 Олон улсын тэмцээнд 80-аас доошгүй хувийн хожил авбал
- 2.4 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа 1-2 байрт шалгарвал

#### **3. Спортын дэд мастер**

- 3.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлбэл
- 3.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 4-өөс доошгүй удаа эхний 3 байрт шалгарвал
- 3.3 Холбооны цомын төлөө болон Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнүүдэд 4-өөс доошгүй удаа түрүүлбэл

### **Арван тав. БЕЙСБОЛ**

#### **1. Олон улсын хэмжээний мастер**

- 1.1 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шилдэг 16-д шалгарвал



1.2 Тивийн аварга шалгаруулах тэмцээн болон Азийн спортын наадамд багаараа эхний 6 байрт орвол.

1.3 Залуучуудын тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт байр эзэлбэл.

1.4 Дээрх тэмцээнүүдэд оролцож багаараа медальт ба шагналт байранд шалгараагүй боловч хувийн амжилтаар тухайн тэмцээний шилдэг тоглогчоор шалгарвал.

## 2. Спортын мастер

2.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд тоглож багаараа 3 удаа түрүүлж бөмбөгийг 10 цөлж /хомран/, 20-30 удаа гаднах талбайд цохиж, тоглолтуудад 15-20 оноо авч, өрсөлдөгчөө 10-15 удаа тоглолтоос гаргасан /аут/ байвал

2.2 Олон улсын Нөхөрлөл тэмцээнд медальт байранд эсвэл Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд тоглож багаараа 2 удаа 1-р байрт шалгаран бөмбөгийг 10 удаа цөлж /хомран/, гаднах талбайд 15 удаа цохиж, 12 оноо авч 8-12 удаа өрсөлдөгчөө тоглолтоос гаргасан /аут/ байвал

2.3 Таваас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд шагналт байранд шалгаран бөмбөгийг 5 удаа цөлж, 5 удаа гаднах талбайд цохиж /хомран/, 4-6 удаа өрсөлдөгчөө тоглолтоос гаргасан байвал.

2.4 Монголын бейсболын холбооны Лигийн аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа аварга, 1 удаа 2-р байрт орвол.

2.5 Монголын бейсболын холбооны улсын шигшээ багт багтан олон улс, тив дэлхийн тэмцээн эсвэл холбооны Лигийн тэмцээнд шагналт байр болон шилдэг тоглогчоор 3 удаа шалгарвал

## 3. Спортын дэд мастер

3.1 Улсын болон хотын аварга, Монголын Бейсболын Холбооны цомын тэмцээн, 2 ба түүнээс дээш орон оролцсон тэмцээнд 2 удаа медальт байрт шалгарсан, бөмбөгийг 10 цөлж /хомран/, гаднах талбайд 15 удаа цохиж, 12 оноо авч өрсөлдөгчөө 15 удаа тоглолтоос гаргасан /аут/ байвал

3.2 Монголын бейсболын холбооны Лигийн аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа дараалан аварга болж, бөмбөгийг 5 удаа цөлж /хомран/, гаднах талбайд цохиж, 12 оноо авч өрсөлдөгчөө 15 удаа тоглолтоос гаргасан /аут/ байвал

3.3 Өсвөр үеийн шигшээ багт багтан олон улсын чанартай тэмцээнд шагналт байранд багаараа эсвэл шилдэг тоглогчоор шалгарвал, бөмбөгийг 3 удаа цөлж, гаднах талбайд 8 удаа цохиж /хомран/, 10 оноо авч өрсөлдөгчөө 12 удаа тоглолтоос гаргасан /аут/ байвал.

3.4 Улсын болон хотын аварга шалгаруулах тэмцээн, эсвэл түүнтэй дүйцэхүйц том хэмжээний тэмцээнд 2 удаа түрүүлж, 1 удаа 2-р байрт шалгаран мөн шилдэг тоглогчоор 2-3 удаа шалгарвал, бөмбөгийг 10 удаа цөлж, гаднах талбайд 15-20 удаа цохиж, 15 оноо авч өрсөлдөгчөө 12 удаа тоглолтоос гаргасан /аут/ байвал.

Тайлбар: Дээрх тэмцээнүүдэд 8-аас доошгүй баг оролцсон тохиолдолд олгоно.

### Арван зургаа. ВОЛЕЙБОЛ


## 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Азийн аварга, Азийн оюутны аварга шалгаруулах, "Универсиад", Азийн наадамд медальт байрт шалгарсан багийн үндсэн тоглогчид ба сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.



1.2 Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээн болон Зүүн Азийн спортын наадам, түүнтэй адилтгах дөрвөөс дээш орон оролцсон олон улсын тэмцээнд хоёр удаа медальт байрт шалгарсан багийн үндсэн тоглогчид ба сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.

1.3 Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээн болон Зүүн Азийн спортын наадам, түүнтэй адилтгах дөрвөөс дээш орон оролцсон олон улсын тэмцээнд медальт байрт нэг удаа шалгарч тухайн тэмцээний аль нэг шилдэг тоглогчоор шалгарвал



## **2. Спортын мастер**

2.1 Үндэсний Лигийн аварга шалгаруулах тэмцээний аварга болсон багийн үндсэн тоглогчид ба сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.

2.2 Үндэсний Лигийн аварга шалгаруулах тэмцээний нэг мөнгө, нэг хүрэл медаль авсан багийн үндсэн тоглогчид ба сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.

2.3 Үндэсний Лигийн аварга шалгаруулах тэмцээний гурван хүрэл медаль авсан багийн үндсэн тоглогчид ба сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.

2.4 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн болон Монголын бүх ард түмний спортын их наадмын гурван удаагийн аварга болсон багийн үндсэн тоглогчид ба сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.

2.5 Насанд хүрэгчдийн улсын шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаж үндсэн багт тогловол

2.6 Үндэсний Лигийн тэмцээний аль нэг шилдэг тоглогчоор нэг удаа шалгарвал

2.7 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн болон Монголын бүх ард түмний спортын их наадмын гурван удаагийн шилдэг тоглогчоор шалгарвал

2.8 Бүх ард түмний спортын наадамд түрүүлсэн багийн тоглогч болон сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.

## **3. Спортын дэд мастер**

3.1 Залуучуудын улсын шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаж олон улсын тэмцээнд орвол.

3.2 Үндэсний Лигийн аварга шалгаруулах тэмцээний хоёр удаагийн аварга болсон багийн бүрэлдэхүүнд багтвал.

3.3 Үндэсний Лигийн аварга шалгаруулах тэмцээний медальт байрт дөрвөн удаа шалгарсан багийн бүрэлдэхүүнд багтвал

3.4 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн болон Монголын бүх ард түмний спортын их наадмын нэг удаагийн аварга болсон багийн үндсэн тоглогчид ба сэлгээгээр орон нийт тоглолтын 60 хүртэл хувьд тогловол.

3.5 Холбооны төлөвлөгөөнд тусгагдсан 18-аас дээш насны ангиллын нэрэмжит тэмцээнүүдээс дөрвөн медаль авсан ба хоёр удаа шилдэг тоглогчоор шалгарвал

3.6 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2 алтан медаль авч, аль нэг шилдэг тоглогчоор нэг удаа шалгарвал

3.7 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт, 1 мөнгөн медаль авч, хоёр удаа шилдэг тоглогчоор шалгарвал




3.8 Өсвөр үеийн шигшээ багт тоглож, олон улсын чанартай тэмцээнд медальт байрт шалгарсан багийн үндсэн тоглогч ба сэлгээгээр тоглон нийт тоглолтын 60-аас дээш хувьд тогловол

3.9 Ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд багийн үндсэн тоглогчоор тоглон гурван медаль авбал

3.10 Оюутны спортын наадмын нэг удаагийн аварга, хоёр удаагийн мөнгө, гурван удаагийн хүрэл медаль авсан багийн үндсэн тоглогчид багтвал

3.11 Монголын бүх ард түмний спортын их наадамд мөнгө, хүрэл медаль хүртсэн багийн үндсэн тоглогч ба шилдэг тоглогчоор шалгарвал



## Арван долоо. ГАНДБОЛ

### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1. Азийн аварга, Азийн болон зүүн өмнөд Азийн тоглолтод шигшээ багийн бүрэлдэхүүнд оролцож, 1-2 статистик үзүүлэлтээр эхний 3 байранд шалгарвал

1.2. Дөрвөөс дээш орон оролцсон олон улсын тэмцээнд багаараа эхний 3 байранд орж, өөрөө шилдэг тоглогчоор шалгарвал

1.3. Оюутны, залуучуудын дэлхийн, тивийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 10 байр эзэлбэл

1.4. Дээрх тэмцээнүүдэд оролцож баг нь медальт байрт шалгараагүй боловч хувийн амжилтаараа /статистик үзүүлэлтээр/ тухайн тэмцээний шилдэг арван тамирчинд багтаж чадсан бол

1.5. Зургаагаас доошгүй орон оролцсон олон улсын тэмцээнд медальт байранд шалгарсан бол;

### 2. Спортын мастер

2.1. Олон улсын тэмцээнд шилдэг 8 багт шалгарвал

2.2. Олон улсын тэмцээнд шилдэг тоглогчоор шалгарч тоглолтын 80%-д талбайд тоглосон байх

2.3 Өсвөр үеийн шигшээ багийн бүрэлдэхүүнд орж тив, дэлхий, олон улсын тэмцээнд оролцож шилдэг 16 багт шалгарвал

2.4 Сүүлийн 3 жилд насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд багийн үндсэн бүрэлдэхүүнд орж тоглолтын 80%-д тоглож 3 удаа түрүүлж, 1 удаа 2-р байр эзэлсэн бол

### 3. Спортын дэд мастер

3.1. Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 2 удаа түрүүлж 1 удаа шагналт байр эзэлсэн бол

3.2. Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 2 удаа түрүүлж 1 удаа шагналт байр эзэлсэн бол

3.3 Улсын аварга шалгаруулах тэмцээнтэй дүйцэхүйц тэмцээнд /Оюутны их наадам,

3.4 Монголын Гандболын холбооны цом, хотын аварга шалгаруулах тэмцээн/ 2 жил дараалан түрүүлж 1 удаа 2-р байрт орж, 1-2 удаа “Шилдэг тоглогч”-оор шалгарвал



#### 4. Улсын шүүгч

4.1 Монгол улсад зохион байгуулсан олон улс, олон улсын уулзалт тэмцээнүүдэд талбайн шүүгчээр оролцож сайн үнэлэлт авсан, дотоодод зохион байгуулагдсан тэмцээнд жилд 3-аас доошгүй удаа гурван жил дараалан шүүж оролцсон, улсын аварга, өсвөр, залуучууд, оюутны улсын аварга шалгаруулах тэмцээн, холбооны цом, нэрэмжит тэмцээнд ерөнхий шүүгч, нарийн бичгийн дарга, шүүгчдийн комиссын гишүүний албан тушаалыг гүйцэтгэсэн хүмүүст олгоно.

4.2 Олон улсын тэмцээн, тивийн аварга шалгаруулах тэмцээн, тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шүүгчээр уригдан ажилласан бол олгоно.

4.3 Олон улсын шүүгчийн семинарт 2-оос доошгүй удаа хамрагдаж, шүүгчийн болзлоо дээрх үзүүлэлтийн дагуу биелүүлсэн байна.

### Арван найм. МОДОН БӨМБӨГ

#### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Дэлхийн /оюутны/ аварга шалгаруулах тэмцээний ганцаарчилсан, баг, хос, холимог хос төрөлд медальт байр эзэлбэл;

1.2 Дэлхийн /оюутны/ аварга шалгаруулах тэмцээний ганцаарчилсан, баг, хос, холимог хос төрөлд шагналт 4-6 байрт шалгарвал;

1.3 Тивийн /элсний, бүсийн, оюутны/ спортын наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээн болон цомын төлөө тэмцээний ганцаарчилсан, баг, хос, холимог хос тоглолтод эхний 3 байрт шалгарсан тохиолдолд;

1.4 Зургаагаас доошгүй орон оролцсон олон улсын тэмцээний ганцаарчилсан, баг, хос, холимог хос төрөлд медальт байранд шалгарвал;

1.5 Олон улсын тэмцээнүүдэд 4 удаа ганцаарчилсан, баг, хос, холимог хос төрөлд медальт байранд орсон бол;

#### 2. Спортын мастер

2.1 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон тивийн аварга шалгаруулах тэмцээнд /оюутны/ 2 удаа оролцож 7-8 байрт шалгарвал;

2.2 Зургаагаас доошгүй орон оролцсон Олон улсын тэмцээний багийн болон ганцаарчилсан төрөлд медальт ба шагналт байрт 2 удаа шалгарвал;

2.3 Улсын аварга шалгаруулах тэмцээний ганцаарчилсан төрөлд 3 удаа түрүүлсэн, баг болон холимог хос, хос тоглолтын аль нэгэнд нь 5 удаа аварга болсон тохилдолд;

#### 3. Спортын дэд мастер

3.1 Улсын аварга шалгаруулах тэмцээний аль нэг төрөлд 3 удаа түрүүлбэл;

3.2 Улсын аварга шалгаруудах тэмцээнд 5 доошгүй удаа оролцож эхний 3 байрт шалгарвал;

3.3 Холбооны цомын болон түүнтэй адил зэрэглэлийн нэрэмжит тэмцээнүүдэд 5-аас доошгүй удаа түрүүлбэл;

3.4 Олон улс, олон улсын уулзалт тэмцээний аль нэгэн төрөлд эхний 3 байрт 2 удаа шалгарвал;

#### **4. Улсын шүүгч**

4.1 Монгол улсад зохион байгуулсан тивийн болон олон улс, олон улсын уулзалт тэмцээнд талбайн шүүгчээр оролцож сайн үнэлэлт авсан, дотоодод зохион байгуулагдсан тэмцээнд жилд 3-аас доошгүй удаа гурван жил дараалан шүүж оролцсон, улсын аварга, холбооны цом, нэрэмжит тэмцээнд ерөнхий шүүгч, нарийн бичгийн дарга, шүүгчдийн комиссын гишүүний албан тушаалыг гүйцэтгэж ажилласан хүмүүст олгоно.

4.2 Олон улсын тэмцээн, тивийн аварга шалгаруулах тэмцээн, тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шүүгчээр уригдан ажилласан бол олгоно.

4.3 Олон улсын шүүгчийн семинарт 2-оос доошгүй удаа хамрагдаж, шүүгчийн болзлоо дээрх үзүүлэлтийн дагуу биелүүлсэн байна.

### **Арван ес. РЕГБИ**

#### **1. Олон улсын хэмжээний мастер**

1.1 Дэлхийн цомын төлөөр урьдчилсан тэмцээн, Ази тивийн болон олон улсын дээд зэрэглэлийн тэмцээнд медальт байрт шалгаран шилдэг тоглогчийн шагнал хүртвэл.

#### **2. Спортын мастер**

2.1 Монголын Регбийн холбооны лигийн аварга шалгаруулах тэмцээнд тоглож хувийн үзүүлэлтээр дараах болзлын аль нэгийг биелүүлсэн тохиолдолд:

а/ нэгдүгээр байрт 3 удаа

б/ нэгээс хоёрдугаар байрт 4 удаа

в/ шилдэг тоглогчоор хоёр удаа шалгарвал

2.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд нэгдүгээр байрт хоёр удаа эсвэл хоёроос гуравдугаар байрт дөрвөн удаа шалгарч шилдэг тоглогчийн шагнал хүртвэл

#### **3. Спортын дэд мастер**

3.1 Монголын Регбигийн холбооны лигийн тэмцээнд хоёроос дээш байрт гурван удаа, хоёроос дөрөвдүгээр байрт дөрвөн удаа шалгарвал

3.2 Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд эхний 3 байрт гурван удаа шалгарвал

3.3 Таваас доошгүй баг оролцсон олон улсын тэмцээнд 3 удаа эхний хоёр байрт шалгарсан тохиолдолд

3.4 Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний хоёр байрт гурван удаа шалгарвал

Жич: Дээрх тэмцээнүүдэд шилдэг тоглогчийн шагнал авсан байх.

### **Хорь. САГСАН БӨМБӨГ**

#### **1. Олон улсын хэмжээний мастер**



1.1 Азийн аварга, Азийн болон зүүн өмнөд Азийн тоглолтод шигшээ багийн бүрэлдэхүүнд оролцож 1-2 статистик үзүүлэлтээр эхний 3 байрт шалгарвал

1.2 4-өөс дээш орон оролцсон олон улсын тэмцээнд багаараа эхний 3 байранд орж, өөрөө шилдэг тоглогчоор шалгарвал

## 2. Спортын мастер

### Эрэгтэй

2.1 Монголын сагсан бөмбөгийн холбоо /МСБХ/-ны үндэсний дээд лигийн тэмцээнд 1 удаа түрүүлж багийн үндсэн бүрэлдэхүүнд бүх тоглолтын 80 хувьд тоглосон байх.

2.2 Монголын сагсан бөмбөгийн холбооны үндэсний дээд лигийн тэмцээнд 2-оос доошгүй удаа 2-3 дугаар байрт шалгаран бүх тоглолтын 80 хувьд үндсэн бүрэлдэхүүнд тоглосон байх

2.3 Үндэсний дээд лигийн тэмцээний шилдэг тоглогчоор нэг удаа шалгарвал

2.4 Үндэсний дээд лигийн тэмцээний бүх оддын тоглолтонд гурван удаа шалгарч Монголын бүх ард түмний спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээний эхний байрт шалгарвал. /тэмцээний 80 хувьд тоглосон байх/

### Эмэгтэй

2.5 Монголын сагсан бөмбөгийн холбооны лиг, оюутны лиг, Монголын бүх ард түмний спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, 2 удаа 2-3 дугаар байрт шалгарвал /үндсэн бүрэлдэхүүнд 80% тоглосон байх/

2.6 Дээрх тэмцээнүүдэд шилдэг тоглогчоор шалгарч, баг нь эхний 3 байрт шалгарвал

## 3. Спортын дэд мастер

### Эрэгтэй

3.1 Монголын сагсан бөмбөгийн холбооны хөгжлийн лигийн тэмцээнд 1 удаа түрүүлж багийн үндсэн бүрэлдэхүүнд бүх тоглолтын 80 хувьд тоглосон байх.

3.2 Монголын сагсан бөмбөгийн холбооны хөгжлийн лигийн тэмцээнд 2-оос доошгүй удаа 2-3 дугаар байрт шалгаран бүх тоглолтын 80 хувьд үндсэн бүрэлдэхүүнд тогловол

3.3 Монголын бүх ард түмний спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээний эхний 3 байрт шалгарвал. /тэмцээний 80 хувьд тоглосон байх/

### Эмэгтэй

3.4 Улсын аварга шалгаруулах болон улсын чанартай тэмцээнд нэг удаа түрүүлж, нэг удаа медальт байранд шалгарвал /тоглолтын 80-аас доошгүй хувьд оролцсон байх/

3.5 Дээрх тэмцээнд баг нь медальт байранд 3 удаа шалгарвал /тоглолтын 80-аас доошгүй хувьд оролцсон байх/

## 4. Улсын шүүгч

4.1 Шүүгчийн сургалтад хамрагдаж, Монголын сагсан бөмбөгийн холбооны үндэсний дээд лигийн тэмцээнд 5 улирал, хөгжлийн лиг, улсын аварга шалгаруулах тэмцээнд 7 улирал шүүгчээр ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллавал

## Хорин нэг. СОФТ ТЕННИС



### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хос болон ганцаарчилсан тоглолтод эхний 6 байрт шалгарвал
- 1.2 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд багаараа медальт байрт шалгарвал
- 1.3 Тивийн спортын наадам, тивийн аварга шалгаруулах болон дэлхийн цомын тэмцээнд багаараа эхний 4 байрт шалгарвал

### 2. Спортын мастер

- 2.1 Таваас доошгүй орон оролцсон олон улсын тэмцээнд эхний 3 байрт шалгарвал
- 2.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа, хотын аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа шалгарвал
- 2.3 Олон улсын тэмцээнд 80-аас доошгүй хувийн хожил авбал
- 2.4 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа, хотын аварга шалгаруулах тэмцээнд 4 удаа 2-р байрт шалгарвал

### 3. Спортын дэд мастер

- 3.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлбэл
- 3.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 4-өөс доошгүй удаа эхний 3 байрт шалгарвал
- 3.3 Олон улсын тэмцээнд 60-аас доошгүй хувийн хожил авбал
- 3.4 Холбооны цомын болон үүнтэй адил зэрэглэлийн нэрэмжит тэмцээнд 4-өөс доошгүй удаа түрүүлбэл.

## Хорин хоёр. ТАЛБАЙН ТЕННИС

### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Тивийн спортын наадам, тивийн аварга шалгаруулах тэмцээнд шилдэг 8 тамирчинд шалгарвал
- 1.2 Тивийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарвал
- 1.3 Олон улсын теннисний холбооны албан ёсны цомын тэмцээнд медальт байрт шалгарвал
- 1.4 6-аас доошгүй орон оролцсон олон улсын тэмцээнд 2 удаа медальт байрт шалгарвал

### 2. Спортын мастер

- 2.1 Таваас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд медальт байрт шалгарвал
- 2.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлж, 1 удаа медальт байрт шалгарвал

### 3. Спортын дэд мастер

- 3.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа 2-р байр, 1 удаа 3-р байрт шалгарвал
- 3.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарч Улаанбаатар хотын их наадамд ба хотын аваргад 2 удаа түрүүлбэл
- 3.3 Холбооны цомын тэмцээнд 2 удаа түрүүлж, рейтинг олгох тэмцээнд 2 удаа түрүүлбэл



## Хорин гурав. ХӨЛ БӨМБӨГ



### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Дэлхийн ба олимп, тивийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан буюу бүсийн тоглолтод эхний 3 байрт шалгарвал
- 1.2 Дэлхийн ба олимп, тивийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан буюу бүсийн тоглолтод шилдэг тоглогчоор шалгарвал

### 2. Спортын мастер

- 2.1 4-өөс доошгүй улсын баг оролцсон, олон улсын албан ёсны тэмцээнд 1-р байрыг 1 удаа эзэлж, эсвэл шилдэг тоглогчоор шалгарвал
- 2.2 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлж, Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн тэмцээнээс эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл
- 2.3 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, 2 удаа 2-р байр эзлэн, Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн тэмцээнээс эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл
- 2.4 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, 3 удаа 3 дугаар байр эзлэн Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн тэмцээнээс эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл
- 2.5 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, 2,3 дугаар байрыг тус бүр 1 удаа, Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн тэмцээнд эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл.

### 3. Спортын дэд мастер

- 3.1 Дөрвөөс доошгүй орон оролцсон албан ёсны олон улсын тэмцээнд 2,3-р байрыг 1 удаа эзэлбэл
- 3.2 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 1 удаа түрүүлж, Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн бусад тэмцээнд эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл
- 3.3 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа 2-р байр эзэлж, Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн бусад тэмцээнд эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл
- 3.4 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа 3-р байр эзэлж, Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн бусад тэмцээнд эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл
- 3.5 Үндэсний лигийн аварга шалгаруулах тэмцээнд 2,3-р байрыг тус бүр 1 удаа эзэлж, Монголын хөл бөмбөгийн холбооны дээд зэрэглэлийн бусад тэмцээнд эхний хоёр байрыг 2 удаа эзэлбэл.

## Хорин дөрөв. ШИРЭЭНИЙ ТЕННИС

### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Ганцаарчилсан төрлөөр Дэлхийн болон тивийн аварга шалгаруулах тэмцээнд хувийн үзүүлэлтээр 10-аас дээш хожил авсан тохиолдолд

1.2 Тивийн аварга болон Дэлхийн хүүхэд залуучуудын спортын наадмуудад эхний 5 байранд шалгарвал

## **2. Спортын мастер**

2.1 Монголын бүх ард түмний спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнд нэг удаа түрүүлбэл

2.2 Улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа 2-р байр эзэлбэл

2.3 Улсын аварга шалгаруулах тэмцээнд гурван удаа эхний 4 байранд шалгарвал

2.4 Олон улсын А зэрэглэл, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний шагналт байранд орвол

## **3. Спортын дэд мастер**

3.1 14-өөс дээш насны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн болон хүүхдийн их наадамд түрүүлбэл

3.2 14-өөс дээш насны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа 2-дугаар байранд шалгарвал

3.3 14-өөс дээш насны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд гурван удаа 3-р байранд шалгарвал

3.4 Насанд хүрэгчдийн хот, аймаг, орон нутгийн аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлбэл

3.5 Ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд нэг удаа түрүүлбэл, 2 удаа 2-р байр, 3 удаа 3-р байранд орвол

Тайлбар: Дээрх цолуудыг зөвхөн ганцаарчилсан тоглолтын амжилтыг үнэлж олгох болно.

## **Дөрөвдүгээр бүлэг. ТЕХНИК СПОРТЫН ТӨРӨЛ**

### **Хорин тав. АВТО ЗАГВАРЫН СПОРТ**

#### **1. Спортын мастер**

1.1 Олон улсын чанартай тэмцээнд медальт байранд 2 удаа, улсын чанартай тэмцээнд 3 удаа түрүүлсэн спортын дэд мастерт олгоно.

#### **2. Спортын дэд мастер**

2.1 Олон улсын чанартай тэмцээнд медальт байранд 1 удаа, улсын чанартай тэмцээнд 3 удаа эхний 2 байр эзэлбэл.

#### **3. Улсын шүүгч**

3.1 Шүүгчийн семинарт 3-аас доошгүй удаа сууж, холбооны толовлогоогоор зохих тэмцээн, улс болон нийслэлээс зохиогдсон техник загварын спортын тэмцээнд ерөнхий болон ахлах шүүгчээр 3 удаа ажиллаж үүргээ сайн биелүүлсэн I зэргийн шүүгчид

### **Хорин зургаа. АВТОМАШИНЫ СПОРТ**



Спортын цол олгох уралдааны төрөл:

- RALLY – Ралли /өртөөчилсэн олон гараатай цуврал уралдаан/
- CROSS COUNTRY RALLY–Холын зайн уралдаан /250 км– 10000 км хүртэлх/
- TOURING – Аялал



### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Монголын автомашин мотоциклийн спортын холбооноос зохион явуулдаг /3-аас дээш орон оролцсон/ олон улсын уралдаанд тогтмол оролцож:

а/ 1, 2 дугаар байрт 2 удаа орвол

б/ 3 дугаар байраас дээш байрт 3 удаа шалгарвал, гэхдээ уралдаанд оролцогчдын 50 хувиас доошгүй нь өндөр цолтой тамирчид оролцсон тохиолдолд

### 2. Спортын мастер

2.1 Гурав хүртэлх орон оролцсон олон улсын чанартай уралдаанд медальт байранд 2-оос доошгүй байр эзэлвэл

2.2 Монголын бүх ард түмний спортын их наадам, Улсын аварга шалгаруулах уралдаан болон холбооны цомын уралдаанд 2 удаа түрүүлэх эсвэл Монголын автомашин мотоциклийн спортын холбоо, Батлан хамгаалах техникийн зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан уралдаанд жилдээ 5-аас доошгүй удаа оролцож медальт байранд 3 удаа шалгарвал

2.3 Аяллын замын урт 1200км – 10000км, батлагдсан маршрутын дагуу аялж, ууланд авирах, цастай орчинд аялахад амжилттай оролцсон.

Жич: Уралдаанд оролцогчдын 50-аас доошгүй хувь нь спортын цолтон байх, уралдаан бүрт 10-аас доошгүй тамирчин, 8-аас доошгүй баг орсон тохиолдолд дээрх заалт биелэгдсэн гэж үзнэ.

### 3. Спортын дэд мастер

3.1 Гурав хүртэлх орон оролцсон олон улсын уралдаанд 2 удаа медальт байрт шалгарвал

3.2 Монголын бүх ард түмний спортын их наадам, Улсын аварга шалгаруулах уралдаан, 2 орны нөхөрсөг уулзалт уралдаан, холбооны цомын төлөө уралдаануудад оролцож:

а/ 1 удаа түрүүлж, шагналт байрт 2 удаа шалгарсан

б/ 2 удаа 2-р байр, 1 удаа шагналт байр

в/ 1 удаа 2-р байр, 2 удаа 3-р байр, 1 удаа шагналт байрт шалгарсан байх

3.3 Монголын автомашин мотоциклийн спортын холбооны салбар зөвлөлийн зохион явуулсан /Аймгийн БХТН-ийн зөвлөлийн/ уралдааны дүн тэмдэглэлийг харгалзан үзэж аймгийн аварга шалгаруулах уралдаанд 2 удаа түрүүлж, 1 удаа 2-р байрт, 1 удаа 3-р байрт шалгарсан тохиолдолд, гэхдээ уралдаанд оролцогчдын тоо 10-аас цөөнгүй, нийт оролцогчдын 50-аас доошгүй хувь нь улсын цолтой байх.

### Хорин долоо. АГААРЫН СПОРТ

## НИСЭХ ЗАГВАРЫН СПОРТ

Нислэг	Ангилал	НЗС-ын их ангиллын болзол		
		ОУХМ	СМ	ДМ
ЧӨЛӨӨТ	F1A	1290	1260	1200
	F1B	1320	1260	1200
	F1C	1320	1260	1200
	F1G	600	600	570
	F1H	600	600	570
	F1J	600	600	570
	F1P	1260	1260	1200
	F1Q	1260	1260	1200
УРАН	F2B	2100	1900	1750
РАДИО УДИРДЛА ГА	F3A	90-100	90-100	80-89
	F3B	90-100	90-100	80-89
	F3C	1350	1300	1200
	F4B	-	90-100	80-89
	F4C	-	90-100	80-89

### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд шигшээ тоглолтод шалгарвал
- 1.2 5-аас дээш орон оролцсон олон улсын тэмцээнд зохих болзлыг биелүүлж, эхний шагналт 5 байранд шалгарвал

### 2. Спортын мастер, Спортын дэд мастер

- 2.1 Улсын аварга шалгаруулах тэмцээн, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд шалгарч болзол хангавал олгоно.

## ХЭТ ХӨНГӨН АГААРЫН ХӨЛӨГ-ДЕЛЬТАЛЕТ

### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Дэлхийн аварга, дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд эхний 10 байрт шалгарвал.
- 1.2 Тивийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 8 байрт шалгарвал.
- 1.3 Гадаадын 3 хүртэл баг оролцсон тэмцээнд түрүүлбэл, медальт байрт 3 удаа орвол.
- 1.4 500км-т тасралтгүй чөлөөт нислэг үйлдэж чадвал. /тусгай зөвлөл томилогдон ажиглалт хийж, GPS-ээр баталгаажуулна/


### 2. Спортын мастер

- 2.1 Дэлхийн аварга шалгаруулах хагас шигшээ тэмцээнд эхний 8 байрт ба дэлхийн аварга шалгаруулах урьдчилсан уралдаануудад эхний 5 байрт шалгарвал.
- 2.2 Гурваас доошгүй орон оролцсон олон улсын уралдаанд эхний 3 байрт удаа шалгарвал.



2.3 Улсын аварга шалгаруулах тэмцээн, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлсэн ба медальт байранд 3 удаа шалгарвал.

2.4 400км-т тасралтгүй чөлөөт нислэг үйлдэж чадвал. /тусгай зөвлөл томилогдон ажиглалт хийж, GPS-ээр баталгаажуулна/



### 3. Спортын дэд мастер

3.1 Улсын аварга шалгаруулах тэмцээн, Монголын агаарын спортын холбооны цомын аварга шалгаруулах тэмцээнд 1 дүгээр байрт 2 удаа шалгарвал.

3.2 300км-т тасралтгүй чөлөөт нислэг үйлдэж чадвал. /тусгай зөвлөл томилогдон ажиглалт хийж, GPS-ээр баталгаажуулна/

## ШҮХРИЙН СПОРТ

### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Дэлхийн болон цэргийн дэлхийн аваргын тэмцээнд шилдэг 30 тамирчны тоонд багтаж шигшээ тэмцээнд шалгарч оролцвол.

1.2 Тивийн аварга шалгаруулах тэмцээнд багийн дүнгээр эхний 3 байрт ба шилдэг 10 тамирчны тоонд багтаж шигшээ тэмцээнд оролцвол.

1.2 Гурав ба түүнээс дээш орон оролцсон олон улсын тэмцээнд багаараа түрүүлбэл.

1.3 Дээрх тэмцээнүүдэд аль нэг төрөл хувиараа медальт байранд шалгарвал.

### 2. Спортын мастер, Спортын дэд мастер

1.1 Улсын болон хотын аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд шалгарч болзол хангавал.

Хөтөлбөр	Үзүүлэлт	Цол					
		Олон улсын хэмжээний мастер		Спортын мастер		Спортын дэд мастер	
		Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
Хувийн цэг онолт /ассурагу/	Буултын тоо: - Хяналтын тойрог 16 см - Хяналтын тойрог 20 см	5 0.00	5 0.15	3 0.25	3 0.50	3 0.75	3 1.00
Ганцаарчилсан акробат /Style/	Буултын тоо: - Иж бүрдлийг биелүүлэх дундаж хугацаа /сек/	2 7.5	2 7.9	2 9.0	2 9.7	2 10.0	2 14.0
Багийн акробат /Formation akudiving/	- 4 хүний иж бүрдэл дасгалын оноо	6	4	4	3	3	2
Бунезрын акробат /canopy formation/	- 4 хүний дараалсан иж бүрдэл үзүүлбэрийн оноо	6	6	5	3	3	2

## Хорин найм. БУУДЛАГА СПОРТ

### 1. Олон улсын хэмжээний мастер, спортын мастер, спортын дэд мастер

Индекс	Дасгал	Зай	Олон улсын хэмжээний мастер		Спортын мастер		Спортын дэд мастер	
			Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
<b>Хийн урт буу</b>								
ХВ-4	Зогсоо байдлаас 40 сум	10	-	395	-	387	-	380
ХВ-6	Зогсоо байдлаас 60 сум	10	594	-	580	-	570	-
<b>Бага калибрын урт буу</b>								
БКВ-5	3 байдлаас буудах дасгал 60 сум /3x20/	50	-	580	572	570	565	560
БКВ-6	3 байдлаас буудах дасгал 120 сум /3x40/	50	1155	-	1140	-	1125	-
БКВ-9	Хэвтээ байдлаас 60 сум	50	595	594	591	588	587	585
<b>Хийн гар буу</b>								
ХГ-2	Хийн гар буу 40 сум /Залуучууд/	10	-	-	380	-	373	-
ХГ-4	Хийн гар буу 40 сум	10	-	384	-	375	-	370
ХГ-6	Хийн гар буу 60 сум	10	583	-	575	-	565	-
<b>Бага калибрийн гар буу</b>								
БКГ-5	Спорт гар буу, 60 сум /30+30/	25	-	584	580	575	575	570
БКГ-6	Тогтоол буудлагын дугуй хар бай 60 сум	50	565	-	555	-	544	-
БКГ-7	Хурдан буудлагаар 5 бай 30 сум	25	-	-	-	-	285	-
БКГ-8	Хурдан буудлагаар 5 бай 60 сум	25	585	-	575	-	568	-
БКГ-9	Standard Pistol, 30 сум /10+10+10/ Залуучууд	25	-	-	285	-	280	-
<b>Том калибрын стандарт урт буу</b>								
ТКВ-5а	3 байдлаас буудах дасгал 60 сум /3x20/	300	577	-	565	-	550	-
<b>Том калибрын сонгомол урт буу</b>								
ТКВ-5	3 байдлаас буудах дасгал 60 сум /3x20/	300	-	-	573	-	560	-
ТКВ-6	3 байдлаас буудах дасгал 120 сум /3x40/	300	1150	-	1145	-	1135	-
ТКВ-9	Хэвтээ байдлаас 60 сум	300	596	-	593	-	589	-
<b>Том калибрийн гар буу /төвийн галтай/</b>								
ТКГ-2	Тогтоол буудлага, дугуй хар бай 30 сум	25	-	-	-	-	285	-
ТКГ-4	Хурдан буудлага, дугуй хар бай 30 сум	25	-	-	-	-	284	-
ТКГ-5	Center Fire Pistol 60 сум /30+30/	25	585	-	580	-	575	-
ТКГ-10	Standard Pistol 60 сум /20+20+20/	25	580	-	575	-	568	-



## Тайлбар:

1. Монголын буудлага спортын холбооны төлөвлөгөөнд туссан чансаа тогтоох болон улсын чанартай тэмцээнд буудлага спортын дэд мастер, спортын мастер цол хангасан бол журамд заасны дагуу олгоно.
2. Дөрөв буюу түүнээс дээш орон оролцсон олон улсын болон тив дэлхий, олимпийн наадам зэрэг тэмцээнд олон улсын хэмжээний мастерын болзол хангасан бол журамд заасны дагуу олгоно.
3. Монгол улсын дээд амжилтыг Улсын аварга шалгаруулах тэмцээн, Монголын бүх ард түмний спортын их наадам болон олон улс тив дэлхий, олимпийн наадамд шинэчлэн тогтооно. Шинэчлэн тогтооходоо том, бага калибрын дасгалууд нь олон улсын буудлага спортын дүрмийн дагуу задгай тирэнд зохиогдсон байна.

## 2. Улсын шүүгч

- 2.1 Монголын буудлага спортын холбооны 1-р зэрэглэлийн шүүгчээр улсын чанартай буудлага спортын тэмцээнд 3-аас доошгүй жил байны болон галын шугамын шүүгч, 2 жил ахлах шүүгч, 1.5-аас доошгүй жил тооцооны шүүгчээр ажиллаж дадлага туршлагатай болсон бол
- 2.2 1-р зэрэглэлийн шүүгчээр ангилал харгалзахгүйгээр 3 жил дараалан Монголын буудлага спортын холбооны шилдэг шүүгч шагналыг 3-аас доошгүй удаа авсан бол
- 2.3 Монголын буудлага спортын холбооноос болон Олон улс /ISSF/, Ази тив /ASC/-ийн холбоодуудаас эх орондоо зохион явуулсан сургалтуудад тогтмол хамрагдсан байна.

## Хорин ес. МОТОЦИКЛИЙН СПОРТ


Мотоциклийн спортын улсын цол олгох уралдааны төрлүүд

- MOTOCROSS – Мотоциклийн бартаат замын уралдаан
- CROSS COUNTRY RALLY- Холын зайн уралдаан
- ENDURO – Тэвчээр шалгах уралдаан
- МОТО БИАТЛОН – Олон төрөлт
- УРАН ЖОЛООДЛОГО

Мотоциклийн спортын төрлүүдээр спортын цол олгоходоо сүүлийн 2 жилийн дотор уралдаанд үзүүлсэн амжилт, авсан онооны нийлбэрээр цол олгоно.

### 1. Олон улсын хэмжээний мастер

- 1.1 Дэлхийн аварга шалгаруулах болон дэлхийн цом, багийн дэлхийн аварга шалгаруулах уралдаанд оролцож 10 хүртлэх байрт шалгарвал 125cc
- 1.2 Тивийн аварга шалгаруулах цуврал уралдаанууд болон багийн аварга шалгаруулах уралдаануудад, эхний 3 байрт шалгарвал 125cc
- 1.3 Гадаадын 5 аас дээш орон оролцсон уралдаануудад, 2 удаа медальт байрт шалгарвал 125cc
- 1.4 Холын зайн уралдаанд, 5-аас дээш орон оролцсон уралдаан, 2 удаа медальт байрт шалгарсан тохиолдолд.
- 1.5 Ендуро буюу тэсвэрийн уралдаан, Тивийн аварга шалгаруулах уралдаанд оролцож, эхний 5 байрт шалгарвал.



## 2. Спортын мастер

2.1 Тивийн аварга шалгаруулах болон тивийн багийн аварга шалгаруулах уралдаануудад оролцож, эхний 5 байрт шалгарвал. 125сс

2.2 Таваас доошгүй орон оролцсон олон улсын уралдаанд, 1 удаа медальт байрт шалгарвал. 125сс

2.3 Монголын бүх ард түмний спортын их наадам, улсын аварга шалгаруулах, Холбооны цом, хотын аварга шалгаруулах уралдаанд оролцож

а/ 2 удаа 3 дугаар байр, 1 удаа шагналт байр

б/ 1 удаа 2 дугаар байр, 1 удаа 3 дугаар байр, 1 удаа шагналт байр. 125сс

Уралдаанд оролцогчдын 50-аас доошгүй хувь нь спортын цолтой, 20-оос доошгүй хувь нь зэрэгтэн, 10-аас доошгүй хувь нь тамирчин, 8-аас доошгүй баг байна.

2.4 Гурав хүртэлх орон оролцсон уулзалт уралдаанд 2 удаа медальт байрт шалгарвал. 125сс

## 3. Спортын дэд мастер

3.1 Монголын бүх ард түмний спортын их наадам, Улсын аварга шалгаруулах уралдаан, Холбооны цом, Хотын аварга шалгаруулах уралдаанд, 2 удаа медальт байрт 85сс

3.2 Гурван орны нөхөрсөг уулзалт уралдаанд 2 удаа медальт байр 85сс

3.3 МАМСХ, БХТН-ийн Техникийн спортын төвийн зохион явуулдаг төлөвлөгөөт уралдааны 80-аас доошгүй хувьд оролцож, эхний 5 байрт 5 удаа шалгарвал 85сс

## 4. Улсын шүүгч

4.1 Монгол улсад зохиогддог мотоциклийн бартаат замын олон улсын уралдаан, Монголын бүх ард түмний спортын их наадам, холбооны цом, хотын аваргын уралдаанд ерөнхий шүүгч, нарийн бичиг шүүгч, техникийн комиссын дарга зэрэг албыг зөрчилгүй гүйцэтгэсэн, мэргэжил дээшлүүлэх семинарт оролцсон байна.

- Ерөнхий шүүгчээр 3 удаа
- Нарийн бичгийн шүүгчээр 3 удаа
- Тойргийн шүүгч 10 удаа
- Техникийн комисст 5 удаа ажилласан байна.

## Гуч. МОТОБИАТЛОН

### 1. Спортын мастер

1.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд:

а/ 1 удаа түрүүлж 2 удаа медальт байранд шалгарвал

б/ 4 удаа медальт байранд шалгарвал

### 2. Спортын дэд мастер

2.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд:

а/ 2 удаа медальт байранд орж шагналт байранд 3 удаа шалгарвал

б/ 1 удаа медальт байранд орж 5 удаа шагналт байранд шалгарвал



## Гучин нэг. МОТОЦИКЛИЙН УРАН ЖОЛООДЛОГО



### 1. Спортын мастер

1.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд доорх болзлыг хангавал:

а/ 2 удаа гүрүүлэх

б/ 1 удаа гүрүүлж 2 удаа медальт байр

в/ 4 удаа медальт байр

### 2. Спортын дэд мастер

2.1 Улсын аварга шалгаруулах тэмцээнд

а/ 1 удаа гүрүүлвэл

б/ 4 удаа медальт байр эзэлвэл

в/ 2 удаа медальт, 3 удаа шагналт байр эзэлвэл

## Гучин хоёр. РАДИО СПОРТ

### 1. Өндөр хурдны телеграф

1.1 Олон улсын хэмжээний мастер цолыг дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 10, олон улсын тэмцээнд эхний 3 байрын аль нэгийг эзэлсэн тамирчдад олгоно.

1.2 Спортын мастер, спортын дэд мастер цолыг улсын аварга шалгаруулах тэмцээн, техникийн спортын их наадам, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнүүдэд оролцон доорх болзлуудыг хангасан тамирчдад олгоно.

Хүлээн авалт, нэвтрүүлгийн хэмжигдэхүүн /нэг минутанд хүлээх, нэвтрүүлэх хурд/

	Эрэгтэй				Эмэгтэй				Компьютерийн дасгал	
	Хүлээлт		Нэвтрүүлэг		Хүлээлт		Нэвтрүүлэг		RUFZ	MORSE RUNNER
	үсэг	тоо	үсэг	тоо	үсэг	тоо	үсэг	тоо		
Спортын мастер	150	150	130	100	140	140	120	90	90-100 оноо	90-100 оноо
Спортын дэд мастер	140	140	120	90	130	130	115	85	80-95 оноо	80-95 оноо

Тайлбар:

а. Хүлээн авах, нэвтрүүлэх дасгалыг зөвхөн нэг минутын хугацаанд гүйцэтгэнэ.

б. Хүлээн авах, нэвтрүүлэх дасгалыг гүйцэтгэх үеийн алдаа нь 3-аас илүүгүй байна.

### 2. Радио пеленгац

2.1 Олон улсын хэмжээний мастер цолыг дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд ангилалдаа эхний 4 байрт, тивийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 3 байрын аль нэгийг эзэлсэн тамирчдад олгоно.

2.2 Спортын мастер, спортын дэд мастер цолыг улсын аварга шалгаруулах тэмцээн болон техникийн спортын их наадамд эхний 3 байрт, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд 1 дүгээр байрт шалгарч доорх болзлыг биелүүлсэн тамирчдад олгоно.

Радио пеленгацын 3.5 МГц-ийн давтамж дээр нууцлагдсан нэвтрүүлэгчдийг илрүүлэн олж барианд орох хугацаа /минутаар/

Насны ангилал	Нас	Илрүүлэх нэвтрүүлэгч	Спортын мастер	Спортын дэд мастер
M - 19	19 хүртэл	4	50 мин	60 мин
W - 19	19 хүртэл	4	55 мин	65 мин
M - 21	19 - 39	5	50 мин	55 мин
W - 21	19 - 35	4	55 мин	60 мин
M - 40	40 - 49	4	55 мин	65 мин
W - 35	35 - 49	4	60 мин	70 мин
M - 50	50 - 59	4	60 мин	70 мин
W - 50	50 дээш	3	65 мин	75 мин
M - 60	60 дээш	3	65 мин	75 мин

Радио пеленгацын 144 МГц-ийн давтамж дээр нууцлагдсан нэвтрүүлэгчдийг илрүүлэн олж барианд орох хугацаа /минутаар/

Насны ангилал	Нас	Илрүүлэх нэвтрүүлэгч	Спортын мастер	Спортын дэд мастер
M - 19	19 хүртэл	4	60 мин	70 мин
W - 19	19 хүртэл	4	65 мин	75 мин
M - 21	19 - 39	5	60 мин	65 мин
W - 21	19 - 35	4	65 мин	70 мин
M - 40	40 - 49	4	65 мин	75 мин
W - 35	35 - 49	4	70 мин	80 мин
M - 50	50 - 59	4	80 мин	90 мин
W - 50	50 дээш	3	85 мин	95 мин
M - 60	60 дээш	3	85 мин	95 мин

Радио пеленгацын замын нийт урт нь агаарын шугамаар 6 – 8 км байна.

Тайлбар: M ангилал нь эрэгтэй.  
W ангилал нь эмэгтэй.

### 3. Сонирхогчийн радио холбоо /богино долгион/

Тэмцээний ангиллууд

- Нэг оператор олон долгионд SOMB
- Олон оператор олон долгионд нэг нэвтрүүлэгчээр MOMB
- Олон оператор олон нэвтрүүлэгч MOMB

#### 3.1 Олон улсын хэмжээний мастер

Дэлхийн аварга шалгаруулах богино долгионы WW DX /Телефон, телеграф, телетайпын төрөл/, WPX DX /Телефон, телеграф, телетайпын төрөл/, IARU WORLD CHAMPIONSHIPS /Телефон, телеграф, холимог төрөл/ тэмцээнүүдэд эхний 10, Азийн аварга шалгаруулах AADX /телефон, телеграфийн төрөл/, Mongolian DX Contest /Телефон, телеграф, телетайпын төрөл/ тэмцээнүүдэд эхний 3 байрыг төрөл, ангилал тус бүрдээ эзэлсэн тохиолдолд олгоно.



3.2 SOSB, SOMB ангиллын тамирчдаас тэмцээний 36 цагт барих хоёр талын холбооны тоо

Холбооны горим	Хоёр талын холбооны тоо	
	Спортын мастер	Спортын дэд мастер
Телегарф /CW/	1800	1600
Телефон /SSB/	2000	1800
Телетайп /RTTY, PSK31/	1000	800

3.3 MOMB, MOMT ангиллын тамирчдаас тэмцээний 12 цагт барих холбооны тоо

Холбооны горим	Хоёр талын холбооны тоо	
	Спортын мастер	Спортын дэд мастер
Телегарф /CW/	700	600
Телефон /SSB/	800	700
Телетайп /RTTY, PSK31/	600	500

4. Радио олон төрөлт

4.1 Спортын мастер, спортын дэд мастер цолыг олон улсын болон улсын аварга, техникийн спортын их наадам, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнээр олгоно.

		Нэг минутанд хүлээн авах хурд	
		Спортын мастер	Спортын дэд мастер
Үсэг	Эрэгтэй	130	120
	Эмэгтэй	120	110
Тоо	Эрэгтэй	130	120
	Эмэгтэй	120	110

		Нэг минутанд нэвтрүүлэх хурд	
		Спортын мастер	Спортын дэд мастер
Үсэг	Эрэгтэй	120	110
	Эмэгтэй	110	100
Тоо	Эрэгтэй	90	80
	Эмэгтэй	80	75


		Радио солилцоо /тамирчид хоорондоо холбоо барих/	
		Спортын мастер	Спортын дэд мастер
Эрэгтэй		21	25
Эмэгтэй		25	28
Холимог баг		23	25

4.2 Радио олон төрөлтийн тэмцээний газар орныг баримжаалах дасгалд дээрх тэмцээнд оролцон эхний 3 байрын аль нэгийг эзэлсэн тамирчдад спортын мастер, 4, 5 дугаар байр эзэлсэн тамирчдад спортын дэд мастер олгоно.

5. Радио хийц

5.1 Спортын мастер цолыг радио хийцийн хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 дүгээр байр эзэлвэл эсвэл 2 дугаар байрт 2 удаа шалгарвал

5.2 Спортын дэд мастер цолыг хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа медальт байранд шалгарвал эсвэл залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд 1 дүгээр байр эзэлвэл



## 6. Улсын шүүгч

6.1 Радио спортын тэмцээнүүдэд шүүгчээр ажилласан шүүгчдэд доорх үнэлгээг өгнө. Улс, хотын аварга, нэрэмжит тэмцээнийг шүүвэл 5 хүртэлх оноо, бусад тэмцээнийг шүүвэл 3 хүртэл оноо. Онооны нийлбэр 25 болвол улсын шүүгч цол олгоно.

## Гучин гурав. УСАН ОНГОЦНЫ ЗАГВАРЫН СПОРТ

Усан онгоцны загварын спортын цолыг Усан онгоцны загварын спортын холбооны төлөвлөгөөгөөр батлагдсан тэмцээнд доорх болзлыг биелүүлсэн тамирчдад олгоно.

### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний эхний 10 байрт шалгарсан, 3 ба түүнээс дээш орон оролцсон олон улсын тэмцээнд медальт буюу шагналт байранд орсон усан онгоцны загварын спортын мастер цолтой тамирчдад.

### 2. Спортын мастер

2.1 Шүүгчдийн бүрэлдэхүүнд улсын шүүгч хоёр, I, II зэрэгтэй шүүгч дөрвөөс доошгүй оролцсон тэмцээнд болзол хангасан спортын дэд мастер

### 3. Спортын дэд мастер

3.1 Шүүгчдийн бүрэлдэхүүнд улсын шүүгч 2, зэрэгтэй шүүгч 4-өөс доошгүй оролцсон 1-р зэргийн тамирчдад

Шулуун хөвөлтийн ЕК, ЕН ангилал, радио удирдлагат F2, F4 ангиллын загваруудын цолны болзол:

Ангилал	Спортын мастер	Спортын дэд мастер
<u>ЕК</u> , <u>ЕН</u>	100	96,6
<u>F2</u> , <u>F4</u>	100	98

Тэмцээний үед дээрх болзлыг биелүүлсэн тамирчдын авсан байх загварын хийцийн оноо ба эзэлсэн байр.

	Спортын мастер	Спортын дэд мастер
Хийцийн оноо	95	90
Эзэлсэн байр	I	II, III

Жич: Салхиар явах яхтын загварын тэмцээний төрөлд оролцсон тамирчдын 50-иас доошгүй хувь нь цолтой байна.



#### 4. Улсын шүүгч

4.1 Хот, улсын аварга шалгаруулах болон олон улсын тэмцээнд ерөнхий шүүгч, ерөнхий шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга, гарааны ахлагчаар 7-оос доошгүй удаа ажиллаж үүргээ алдаа дутагдалгүй сайн биелүүлсэн, усан онгоцны загварын спортын талаар 2-оос доошгүй ном, гарын авлага бичиж нийтлүүлсэн, шүүгчдийн семинар удирдан зохион байгуулсан I зэргийн шүүгчид олгоно



### Гучин дөрөв. ПРАКТИК БУУДЛАГА

#### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1. 5-с цөөнгүй орны тамирчид оролцсон Практик буудлагын спортын 3 ба түүнээс дээш түвшний тэмцээнд 1, 2, 3-р байрыг ганцаарчилсан болон багийн дүнгээр эзэлсэн эсвэл Олон улсын практик буудлагын холбооны зэрэглэлийн дасгалын мастерийн болзол хангасан

#### 2. Спортын мастер

2.1. Үндэсний хэмжээний 3-р түвшний тэмцээнд түрүүлсэн болон Олон улсын практик буудлагын холбооны зэрэглэлийн дасгалын "A" болзол хангасан

#### 3. Спортын дэд мастер

3.1. Үндэсний хэмжээний 3-р түвшний тэмцээнд 2, 3-р байр (авсан оноо нь ялагчийн онооны 60-74,999%-д хүрсэн тохиолдолд) эзэлсэн болон Олон улсын практик буудлагын холбооны зэрэглэлийн дасгалын "B" болзол хангасан.

#### 4. I зэрэг

4.1. Үндэсний хэмжээний 3-р түвшний тэмцээнд шагналт байр эзлээгүй боловч авсан оноо нь ялагчийн онооны 40-59,999 хувьд хүрсэн болон Олон улсын практик буудлагын холбооны зэрэглэлийн дасгалын "C" болзол хангасан.

#### 5. II зэрэг

5.1. 3-р түвшний тэмцээнд шагналт байр эзлээгүй боловч ялагчийн онооны 39,999 хувьд хүртэлх оноо авсан болон Олон улсын практик буудлагын холбооны зэрэглэлийн дасгалын "D" болзол хангасан.

#### 5. Улсын шүүгч

6.1. Монголын практик буудлагын холбооны шүүгчийн сургалтанд хамрагдаж 1 жилд 4-өөс багагүй тэмцээнд шүүгчээр ажилласан.


### Тавдугаар бүлэг. ТУЛААНЫ СПОРТЫН ТӨРӨЛ

#### Гучин тав. БОКС /КИКБОКС (WAKO)/

#### 1. Олон улсын хэмжээний мастер

1.1 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медальт байранд 1 удаа шалгарвал.

- 1.2 Дэлхийн цомын тэмцээн, Тивийн аварга шалгаруулах тэмцээн, тивийн наадмаас 2 удаа медаль авбал.
- 1.3 Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний медальт байранд 2 удаа эсвэл тивийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээнд нэг удаа түрүүлж нэг удаа медальт байранд шалгарахад.
- 1.4 Өсвөр үеийн Дэлхийн аварга шалгаруулах, дэлхийн цомын тэмцээнд нэг удаа түрүүлж нэг удаа медальт байранд шалгарахад.
- 1.5 Дэлхийн Кикбоксын Холбооны А зэрэглэлийн олон улсын тэмцээнд 2 удаа алт, 2 удаа мөнгө медаль авбал.



## **2. Спортын мастер**

- 2.1 Насанд хүрэгчдийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа медаль авч, нэг удаа шилдэг наймд шалгарвал.
- 2.2 Залуучуудын тивийн аварга шалгаруулах тэмцээнд 1, 2 –р байр эзэлвэл.
- 2.3 Олон улсын тэмцээнд 2 удаа эхний 2 байранд шалгарвал.
- 2.4 Монголын бүх ард түмний спортын их наадамд түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа медальт байранд шалгарвал.
- 2.5 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлвэл.
- 2.6 Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 удаа 2 дугаар байр, 3-н удаа 3 дугаар байранд шалгарвал.
- 2.7 Насанд хүрэгчдийн Улаанбаатар хотын аварга шалгаруулах болон залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд тус бүр 2 удаа түрүүлвэл.
- 2.8 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 удаа түрүүлж, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний 2 дугаар байранд 2 удаа шалгарвал.
- 2.9 Өсвөр үеийн ба залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд тус бүр 3 удаа түрүүлж насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2 удаа медаль авбал.

## **3. Улсын шүүгч.**

- 3.1 Шүүгчийн сургалтад хамрагдаж, аливаа тэмцээнийг шүүхдээ ямар нэгэн алдаа дутагдал гаргаагүй байна.
